



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/46

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Чансаатай унага-2019” малчин залуучуудын дунд зохион байгуулсан тэмцээнд амжилттай оролцсон Мянгад сумын Цагаан булан багийн иргэн Ж.Даваажав, Ч.Дорждагва, аймаг, орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, хөгжил цэцэглэлтэнд үнэтэй хувь нэмэр оруулсан Жаргалант сумын Бичигт багийн өндөр настан Р.Лхагважав нарыг Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнахад 90000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулагдах 90000 төгрөг /ерэн мянга/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 23-ны өдрийн
А/46 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНУУЛАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Ж.Даваажав	Мянгад сумын Цагаан булан баг малчин	30000
2	Ч.Дорждагва	Мянгад сум Цагаан булан багийн малчин	30000
3	Р.Лхагважав	Жаргалант сум Бичигт багийн өндөр настан	30000
Дүн			90000

-оОо-